

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 112 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

СХД-ийн 112-р цэцэрлэг нь анх 1986 онд Октябрийн район гэж байхад нээгдэж анхны эрхлэгчээр нь Алимаа гэж томилогдон үйл ажиллагаа эхэлсэн байна. Нэг жилийн дараа 1987 онд АБЯамны цэцэрлэгийн хэлтсийн ажилтан Лувсан овогтой Балжид эрхлэгчээр ирсэн. АДХГЗ-ны 1987 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 236 дугаар тогтоолоор одоогийн СХД-ийн 14-р хорооны нутаг дэвсгэр, Барилгачдын гудамж, Өнөр 1-р хороололд ЗХУ-ын тусламжаар баригдаж ашиглалтанд орсон. Анх нээгдэхдээ 24 цагийн ажиллагаатай 180 хүүхэдтэй 6 бүлэгтэй, 30 багш, ажилтантай байв. 1 бүлэг дээр ээлжийн 2 багш, 3 туслах багш ажиллаж байв. Бүх бүлгүүд мэргэжлийн багштай, оройн багш 2 ангийн дунд ажилладаг байжээ.

Л.Балжид эрхлэгчээр ажиллаж байх үедээ туслах аж ахуйг хөгжүүлэх талаар их анхаарч, цэцэрлэгийн талбайдаа төмс, хүнсний болон нарийн ногоо тарьж, гахай өсгөж, улмаар хүнсний хэрэгцээнд хэрэглэж байжээ.

Хонхорт хүнсний ногооны талбай ажиллуулж хүнсний ногоогоор өөрийн цэцэрлэгийн хэрэгцээг хангадаг байсан. Энэ хугацаандаа СХД-ийн “Тэргүүний соёлч цэцэрлэг” болсон байна.

Тус цэцэрлэгийг удирдаж явсан үе үеийн эрхлэгч нар багш, ажилчдынхаа нийгмийн болон ахуй амьдралд их анхаарал тавьж сургууль, курст сургах, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэхэд тусалж ажиллаж ирсэн бөгөөд багш ажилчдаа дэмжиж ажилласны дүнд багш С.Милмаачин, Должин нар АБЯ-ны “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулж байжээ. Төр засгаас эрхлэгч Л.Балжидын ажлын амжилтыг үнэлж 1991 онд Монгол Улсын “Гавъяат багш” цолоор шагнасан байна. Тухайн үед ажиллаж байсан багш нар 1987 онд Б.Даваасүрэн, Хорлоо, Должин Зэвгээ, дуу хөгжмийн багш Оюун-эрдэнэ, Яслийн багш Сүрэнхорлоо, Уранчимэг, Тунгалаг, Ариунгэрэл, Эрдэнэчимэг, Милмаачин, Цэенхүү, Дэнсмаа, Одонгэрэл, Энхцэцэг, Үржин Тогооч нар: Цэрэнжав, Оюунгэрэл, Тогоохүү, Наташа, Жамбал, Батцэцэг Угаагч: Мөнгөнцэцэг Я.Насандэлгэр, Оюун-эрдэнэ Туслахууд: Энхмандах, Юра, Эрхэмбаяр, Бадам, Цэрэндулам, Нарантуяа, Орломжав, М.Оюунцэцэг, Дуламсүрэн, Баттулга, Д.Даваасүрэн, У.Даваасүрэн Нябо: Туяа, О.Гүндэгмаа, Баясаа, Сэргэлэн Нярав: Лундаажанцан, Өлзийсайхан, Отгон

Слесарь: Тулгаа, Д.Бадамрагчаа нар ажиллаж байсан. Багш ажилчдын амжилтыг үнэлэн:

1996 онд “Байгууллагын аварга” -аар Тогооч Цэрэнжав

1997 онд “Байгууллагын аварга” -аар туслах багш Д.Даваасүрэн

1998 онд “Байгууллагын аварга” -аар Багш О.Энхцэцэг

1999 онд “Байгууллагын аварга” -аар Багш Тунгалаг

2000 онд “Байгууллагын аварга” -аар Тогооч С.Тогоохүү

2001 онд “Байгууллагын аварга” -аар Туслах багш С.Юра

2002 онд “Байгууллагын аварга” -аар багш Л.Жичбилэг

2003 онд “Байгууллагын аварга” -аар Багш Алтанхуяг

2004 онд “Байгууллагын аварга” -аар

2005 онд “Байгууллагын аварга” -аар багш Л.Жичбилэг

2005 онд “Байгууллагын хөдөлмөрийн аварга” –аар ажилчин Ө.Аюушжав

2006 онд “Ажил мэргэжлийн аварга” -аар багш Н.Одонтуяа

2006 онд “Байгууллагын хөдөлмөрийн аварга” –аар туслах багш Л.Баярсайхан нар тус тус шалгарч байв.

Тус цэцэрлэгийн эрхлэгчээр Байгаль 1996-1998 он, Анхтуяа 1998-2000 он, Ц.Нэргүй 2000-2004 он хүртэл тус тус ажиллаж байсан.

Галсандорж овогтой Сүнжидмаа нь Сонгинохайрхан дүүргийн Засаг Даргын 2004 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 238 дугаар захирамжаар СХД-ийн 112-р цэцэрлэгийн эрхлэгчээр томилогдсон бөгөөд цэцэрлэгийн эрхлэгчээр одоог хүртэл ажиллаж байна.

Эрхлэгч Г.Сүнжидмааг тус цэцэрлэгийг хүлээн авахад 8 бүлэг, 38 багш, ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Ажиллах хугацаандаа ашиглагдахгүй байсан 4 бүлгийн 2 бүлгийг нь 2004 онд, үлдсэн 2 бүлгийг 2009 онд тус тус ашиглалтанд оруулж өнөөгийн байдлаар 12 бүлэгт нийт 500 хүүхэд, 43 багш, ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд 2010 онд ашиглагдахгүй байсан 2 сэрүүн өрөөг ашиглалтанд оруулж “Биеийн тамир”-ын танхим болон “Хүүхэд хөгжлийн төв” болгон ашиглаж байна.

2005 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар “ПГС” ХХК-аар гадны магистрал шугам-5ш худгаас узель хүртэл 60 метр, подвальд хэрэглээний халуун хүйтэн усны шугам, мөн бүх ангийн халуун хүйтэн усны шугам зэргийг шинэчлэн сольсон. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2007 онд “Хангилцаг” ХХК нь 9 сая төгрөгөөр халуун хүйтэн усны салбар шугам, угаалтуур жорлон, почки комоор подвальд халуун хүйтэн усны өгөх буцах шугам сольсон.

2010 онд Сэрүүн өрөөний хана тааз, шал шинэчилэхэд 7сая 500 мянган төгрөг зарцуулсан. Уг засварыг “Монтовүүд” ХХК гүйцэтгэсэн.

Цэцэрлэгийн дотоод урсгал засварыг 12 бүлэг, гал тогоо, 7 өрөө тасалгаа, танхимыг засварыг үе шаттай хийж дотоод тав тухтай орчныг бүрдүүлэн ажиллаж ирлээ.

Бакалавр зэрэгтэй багшгийн тоо- 13

Дипломын багш-1

Багшлах эрхтэй багшийн тоо- 15

Заах аргач багш мэргэжлийн зэрэгтэй багш- 9

Удирдлагын академи төгссөн багш -2

МУБИС-ийн магистрт суралцаж байгаа багш- 2

Туслах багшийн дамжаанд суусан- 12

Авто жолооны курс төгссөн -4

Байгууллага хамт олны амжилт: шагнал урамшуулал:

- 2007 онд “Биеийн тамирыг дэмжигч байгууллага”
- 2008 онд Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагын хөгжлийн хөтөлбөр “Амны хөндийн эрүүл ахуй-цэвэр гар” цогц үйл ажиллагааны хүрээнд явагдсан 2 сарын аянд амжилттай оролцож Тусгай байр 500.000 төгрөгийн батламж гардан авсан.
- “Үлгэрийн баатрууд амилсан нь-2007” наадамд Дүүрэгт 1-р байр, хотод тусгай байр ОХУ-ын “Улан-Үдэ” хотноо болсон хүүхдийн “Отречества наадам”-д амжилттай оролцож 3 хүүхэд Шилдэг дүрийн шагнал хүртсэн.
- 2008 онд СХД-ийн “Хийн дасгал”-ын уралдаанд амжилттай оролцож 2- байр Мөнгөн медаль.
- 2010 онд МҮЭ-ийн Соёлын төв ордоноос зохион байгуулж зарласан “Бяцхан ханхүү” тэмцээний 1-р шат болон “Гала” тоглолтонд 4 хүүхэд амжилттай оролцож Өргөмжлөл, хүрэл медалиар шагнагдсан.

- “Бяцхан тод авьяастан -2010” тэмцээнд 4 хүүхдийг оролцуулж тэмцээний тусгай байрын шагнал хүртсэн.
- 2010 онд МҮЭСТО-ны 35 жилийн ойн Ажилтны урлагийн “Гала” тоглолтонд “Найрал дуу”-аар тэргүүн байрт шалгарч МҮЭСТО-ны “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдсан.
- 2010 онд Боловсрол сан СХД-ийн Боловсролын хэлтэстэй хамтран хүүхдийн дунд зохион байгуулсан “Үлгэрийн баатрууд амилсан нь” тэмцээнд “Эрхий мэргэн” үлгэрээр 3-р байранд шалгарч Хүрэл медаль, өргөмжлөл хүртсэн.
- 2010 оны ҮЭ-ийн бүлгийн ажлаараа 3-р байранд шалгарч НХЦҮЭХ-ны Өргөмжлөл мөнгөн шагнал, 1 хүн БНХАУ-ын Бээжин хотоор аялах эрхийн бичиг хүртсэн.
- 2010 онд Монголын ихрүүдийн холбоо, СХД-ийн 14-р хороотой хамтран зохион байгуулсан “Ихэр заяа-2010” цэцэрлэгийн 23 ихрийн баярыг амжилттай тэмдэглэж явууллаа.
- 2011 онд Ширээний теннисийн тэмцээнд эрэгтэй эмэгтэй төрөлд амжилттай оролцож Багш Д.Энхмандах 2-р байр эзэлж Мөнгөн медаль хүртлээ.
- 2011 онд туслах багш Ц.Ганжаргал “Шатар”-аар 1- байр алтан медаль
- 2012 оны “Багшийн ур чадвар” уралдаанд залуу багш Л.Ундармаа СХД-ийн Сэтгэмж” бүсэд 3- байр эзэлж амжилттай оролцсон.
- “2012 оны Биеийн тамир спорт”-ын ажлаараа СХД-т Тэргүүн байранд шалгарч СХД-ийн Засаг даргын Өргөмжлөл алт, мөнгөн медаль хүртсэн.
/2013 оны 1-р сарын 26-нд/
- “2012 оны Биеийн тамир спорт”-ын ажлаараа амжилт гаргаж МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн нэрэмжит “Хүндэт өргөмжлөл” хүртсэн.
- Биеийн тамирын багш Ч.Отгонжаргал нь “Биеийн тамир спортын” ажлаараа амжилт гарган МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн нэрэмжит “Хүндэт өргөмжлөл”- өөр шагнагдсан
- СХД-ийн 2013 оны “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн тэмцээнд амжилттай оролцож 3-р байр 30 хүүхэд хүрэл медаль, өргөмжлөл, Нийслэлийн тэмцээнд оролцох эрхийн бичгээр шагнагдсан.
- 2013 онд МУ-ын Засгийн газраас 2012-2016 онд хэрэгжүүлэх “Ном, авьяас, багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд тайлан, үзэсгэлэн гаргаж “Сэтгэмж” бүсийн эрхлэгч багш нарын дунд болон СХД-ийн болон БХ-ийн удирдлагуудад тус хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлаа нийт- 50 багш, ажилчид, 350 эцэг эхчүүдэд сурталчилсан.

- 2013 онд үйл ажиллагаагаа TV-5, “Шинэ дэлхий”, ”Боловсрол суваг” телевизүүдтэй хамтран ажиллаж өөрийн цэцэрлэгийн үйл ажиллагаагаа сурталчилсан.
- 2012 онд 1 хүн нэг мод “Ногоон байгууламж байгуулах ”сэдэвт аяны хүрээнд нийт- 41 ажилчид чацаргана, нохойн хошуу, долоогоно, голт бор, улиас зэрэг мод , бутыг тарьж хүн тус бүрт хариуцуулан өгсөн. Багш, ажилчдын хүчээр цэцэрлэгийн гадаад талбайд -46 жимсний мод бут суулгаж, цэцгийн мандал-4 ш -ийг байгуулж цэцэрлэгжүүлсэн нийт өртөг -250,000 төгрөг зарцуулсан.
- Эрхлэгч Г.Сүнжидмаа нь ажил үйлсээрээ шалгаран 2008 онд МЗХ-ны “Хөдөлмөрийн алдар” медаль, 2009 онд БСШУЯ-ны БТА цол тэмдэг, 2011 онд НБГ-ын “Хүндэт тэмдэг”, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, 2012 онд СХД-ийн 20 жилийн ойн медаль, 2013 онд НБГ-ын “Шилдэг ажилтан” цол тэмдгээр шагнагдсан.
- 2010 онд МБНХ-ны “Алтан-эрдэнэ” медалиар багш Н.Одонтуяа, арга зүйч Д.Энхцэцэг, ”Есөн-эрдэнэ” медалиар багш Т.Одончимэг, Ачтан багш тэмдгээр багш Д.Оюун-эрдэнэ, Ж.Төмөр-очир нар шагнагдсан.
- 2010 онд өмч хамгааллын ажлаараа шалгаран Нийслэлийн өмчийн харилцааны газрын “Хүндэт өргөмжлөл” хүртсэн.
- 2012 онд СХД-ийн 20 жилийн ойн медалиар 20 багш ажилтан шагнагдсан.
- 2013 онд багш Н.Одонтуяа БСШУЯ-ны БТА цол тэмдгээр шагнагдсан.
- Байгууллага хамт олноо манлайлан ажил үйлсээрээ шалгаран Сангийн яамны “Жуух бичиг”-ээр нягтлан Г.Ганцэцэг, Санхүү банкны 100 жил ойн “медаль”-иар Г.Ганцэцэг, нярав Ц.Найманжин, БСШУЯ-ны “Жуух бичиг”-ээр Арга зүйч Д.Энхцэцэг, багш Л.Жичбилэг, Н.Одонтуяа, Т.Одончимэг, БСШУЯ-ны “Ардын авъяастан” цол тэмдгээр хөгжмийн багш Ч.Намсрай, НБГ-ын “Шилдэг ажилтан” цол тэмдгээр эрхлэгч Г.Сүнжидмаа, арга зүйч Д.Энхцэцэг, тогооч Г.Оюунсүрэн, НБГ-ын “Багшийн алдар” медалиар багш Я.Нарангэрэл, Т.Одончимэг, Л.Амарбаясгалан, НБГ-ын “Ахлах багш” цол тэмдгээр багш Ж.Төмөр-Очир, ”Арга зүйч багш” тэмдгээр багш Х.Агиймаа, МЗХ-ны “Тэргүүний залуу” алтан медалиар багш Д.Болд-Эрдэнэ, туслах багш Ц.Ганжаргал,” ҮЭ-ийн “Хүндэт тэмдэг”-ээр багш Н.Одонтуяа, тогооч Д.Цэрэнжалам, Д.Агмаа, “Хүндэт өргөмжлөл”-өөр Л.Баярсайхан, Б.Түвшинжаргал, П.Саранцэцэг, БАУА-ны холбооны ”Үйлчилгээний хүндэт ажилтан” тэмгээр туслах багш Д.Баярсайхан, Д.Энхмандах, Д.Агмаа,

Л.Гантайхүү, Б.Баярбат 5 ажилчин, Гавъяаны амралтанд байгаа ахмад багш Бадамжав овогтой Цэрэндулам нар тус тус хүртсэн. 2013 онд Ахмад багш Ж.Дэнсмаа нь МБАУА-ны “Багшийн гавъяаны одон”-гоор тус тус шагнагдсан.

- 2010 оны “Байгууллагын аварга” –аар Багш Д.Оюун-эрдэнэ
- 2010 оны “Байгууллагын аварга ажилтан”-аар угаагч Х. Дунгармаа
- 2011 оны “Байгууллагын аварга ” –аар багш Я.Нарангэрэл,
- 2011 оны “Байгууллагын аварга ажилтан” –аар туслах багш Д.Агмаа
- 2012 онд “Байгууллагын аварга ” –аар багш Х.Агиймаа
- 2012 онд “Байгууллагын аварга ажилтан” –аар харуул Б.Гомборагчаа нар шалгарсан.
- 2013 оны цасны баярын “Сумо бөх”-ийн тэмцээнд биеийн тамирын багш Ч.Отгонжаргал амжилттай оролцож хүрэл медаль хүртсэн.

Хоёр. Хөмрөгийн баримтын түүх

Сонгинохайрхан дүүргийн 112 дугаар цэцэрлэг нь өмнө Төрийн архивт цэцэрлэг, яслийн 182 хөмрөгт хөмрөг үүсгэсэн бөгөөд 1987-1999 оны байнга хадгалах 31 ХН шилжүүлсэн байна. Одоо тус байгууллагын архивт 1987- 2013 он хүртэлх байнга, түр, 70 жил хадгалах баримтууд хадгалагдаж байсан.

Тус байгууллага нь 2013 онд 2000-2012 оны байнгын баримтаар Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу нөхөн бүрдүүлэлт хийхээр нярав, архив бичиг хэргийн ажилтан Ц.Найманжин миний бие нийслэлийн Архивын газрын ажилтан Н.Цацралтуяагаас мэргэжил арга зүйн зааварчилгаа аван байгууллагын архивт хадгалагдаж буй 1987-2012 оны архивын баримтад 2013 оны 10 дугаар сарын 16-наас 2013 оны 11 дүгээр сарын 27-ныг дуустал хугацаанд эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Баримтын бүрдэл:

Байнга хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: Эрхлэгчийн тушаал, хурлын тэмдэглэл, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, биелэлт, хичээлийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, ирсэн, явуулсан бичиг, санхүүгийн жилийн эцсийн тайлан тэнцэл, нийгмийн даатгалын тайлан, үндсэн хөрөнгийн жилийн эцсийн бүртгэл зэрэг баримтуудаас бүрдэж байна

70 жил хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: цалингийн карт, цалингийн тооцооны хуудас, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны хуудас, Эрхлэгчийн “Б” тушаал зэрэг баримтуудаас бүрдэж байна.

Түр хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: Ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдол, бэлэн мөнгөний орлого, зарлага, касс, харилцах, цалингийн баримтууд, хүүхдийн хоолны мөнгөний тооцоо, няравын тайлан, аж ахуйн гэрээ, санхүүгийн улирлын тайлан тэнцэл, үндсэн хөрөнгийн хагас жилийн тооллогын бүртгэл зэрэг баримтуудаас бүрдэж байна.

ЭШТБ-ын ажлын явцад:

1.1987-2012 оны баримтуудыг нягтлан шалгаж, ангилан ялгаж, эрхлэгчийн тушаалыг 2008 оноос үйл ажиллагааны болон боловсон хүчний асуудлаар 2 ангилан он, сар, өдрийн дараалалд оруулж, хуудас дугаарлах, үдэж хавтаслах, нуруу цаас наах, нүүр бичилт хийх зэрэг техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2. Ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдлыг ач холбогдол, хадгалах хугацаагаар нь байнга, түр болгож ангилан, хэрэг бүрдүүлж авсан.

3. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдээс тухайн жилд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын жилийн төлөвлөгөө, тайлан, холбогдох баримтуудыг байнгад салган авч, сар, улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан мэдээг түрд үлдээв.

4. 5. Санхүүгийн тайлан тэнцэл, татварын тайлан, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан зэрэг нь санхүүгийн баримтад хамт үдэгдсэн, санхүүгийн баримтын шалгалтад ороогүй, хадгалах хугацаа нь дуусаагүй тул задлалгүй түрийн бүртгэлд нь үлдээв.

6. 2000-2010 оны касс, харилцахын баримт, хүнс материалын тайлан, хүүхдийн хоолны мөнгөний тооцоо, үндсэн хөрөнгө, эд хөрөнгийн хагас жилийн тооллогын бүртгэл баримтуудыг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 7 хэргийн 92 ХН-д устгах хэргийн акт үйлдсэн.

7. Мөн тус цэцэрлэгт хадгалагдаж байсан дүрс бичлэг, гэрэл зургийг ангилан төрөлжүүлж хадгаламжийн нэгж бүрдүүлэн тусгай төрлийн бүртгэл үйлдэн 2010-2012 оны 3 CD бүхий дүрс бичлэгийн, 2010 оны 90 зураг бүхий 1 CD бүхий цахим гэрэл зургийн, 1993-2012 оны гэрэл зургийн цомгийн 2 бүртгэл тус тус үйлдсэн.

8. Нийслэлийн Архивын ажилтны зааврын дагуу нийслэлийн Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй байнга хадгалах 31 ХН бүхий тус цэцэрлэгийн 182/2-ын 11 дүгээр данстай данс нэгтгэж 1987-2012 оны нэгдсэн данс гаргав.

ЭШТБ-ын ажлын үр дүнд:

- 1987-2012 оны 175 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 2002-2012 оны 120 хадгаламжийн нэгж бүхий түрийн бүртгэл,
- 1987-2012 оны 50 хадгаламжийн нэгжийн 70 жилийн бүртгэл,
- 2010-2012 оны 3 CD бүхий дүрс бичлэгийн бүртгэл,
- 2010 оны 90 зураг бүхий 1 CD бүхий цахим гэрэл зургийн бүртгэл,
- 1993-2012 оны гэрэл зургийн цомгийн 2 бүртгэл
- 2000-2010 оны эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 12 нэр төрлийн 66 хадгаламжийн нэгжийг устгах устгах хэргийн актыг тус тус үйлдэв.

Дээрх данс, бүртгэл, актыг Сонгинохайрхан дүүргийн 112 дугаар цэцэрлэгийн дэргэдэх ББНШК-ийн 2013 оны 11 дүгээр сарын 28-ны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн нийслэлийн Архивын газрын дэргэдэх ББНШАЗК-ийн хурлаар оруулахаар шийдвэрлэв.